

МУЗЕЙН ҮЗМЭРИЙН ШИНЭЧИЛСЭН ДАНСНЫ ҮНЭ ТОГТООХ ТУХАЙ ЗАГВАРЧИЛСАН ЗӨВЛӨМЖ

Ерөнхий бүртгэлд нэг хувийн дугаарт олон тоогоороо бүртгэгдсэн нэг эх сурвалжтай ижил буюу ижил төстэй (нэг хэвийн бурхад, цөгц, гэрэл зураг, биримт бичиг, зэв, чулуун зэвсэг, цуврал эскиз зураг г.м) үзмэр, эд өлгийн зүйлийн үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан бүртгэлийн үнийг нийтэд нь буюу нэг бүрчлэн тогтоон нэгтгэж болно.

Жишээ 1. Нэг хувийн дугаартай тал хэвийн “Майдар” 35 ширхэг шавар бурханыг шинэчилсэн үнийг тогтоохдоо нэг бүрчлэн биш нийтэд нь үнэлье, ингэхдээ “Түүх, соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ын 4.2.4-т заасан Хагас товгор бурхан /жигжиг хэмжээтэй/ - 100,000.0 ₮ -ийг сонгоно. Олон тоогоороо нэг үнэлгээ хийгдэж байгаа учир үнийн дүнгээ 50% хүртэл өсгөж болох бөгөөд энэ үзмэр хэт олон тоотой биш гэж үзсэн учир 30% нэмэгдүүллээ. Ингэснээр “Майдар” бурханы шинэчилсэн дансны/ бүртгэлийн үнэ 130,000.0 ₮-өөр тогтоолоо.

Видео хичээл үзэх линк: www.monheritage.mn/video1.aspx

Жишээ 2. Нэг хувийн дугаартай малгай, дээл, хороомон гутал, цүнхнээс бүрдсэн “Иж бүрэн хувцас” нэртэй үзмэр. Энэ үзмэрийн хувьд журмын 2.22-т заасан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд нэг хувийн дугаарт бүртгэгдсэн өөр өөр эх сурвалж, материал, төрөл зүйлд хамаарах үзмэр, эд өлгийн зүйлийг тус бүрд нь үнэлж нэгтгэнэ” гэсний дагуу үнэ тогтоож болно. Ингэхдээ “Түүх, соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ын 2.1 4-т заасан Түүхэн бие хүний холбогдолтой эд өлгийн зүйл хамаарах боловч журмын 2.24-т заасан “...бодит байдлыг харгалзан зөв төрөлд нь хамруулан үнэлнэ” гэсний дагуу “Угсаатны зүйн ангилалаас үнэллээ.

Дээл 3.5.2.6 Энгийн даавуу, торгон дээл 300,000.0 ₮

Гутал 3.5.4.4 Хоромон болон бусад гутал 300,000.0 ₮

Гэтэл энгийн шилайпан малгай, хойт зүгийн гаралтай энгийн Арьсан цүнх гэсэн ангилал байхгүй байгаа учир журмын 2.23-т заасан “Шинэчилсэн дансны үнийн жагсаалтад ороогүй түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийг ижил төстэй төрөл, зүйлд нь хамааруулан дансны үнийг тогтооно” гэсний дагуу

Цүнхийг 3.2.6.1 Богц 300,000.0 ₮ гэж тогтоолоо.

Малгайг 3.5.1.5 Элдэв чимэггүй энгийн үед өмсдөг хоргой, торго, хилэн малгай / тоорцог, лоовууз, юүдэн зэрэг/ 300,000.0 ₮ сонголоо. Ингэхдээ орчин цагийн хийц учир журмын 2.8. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн бүтээсэн он цагийг харгалзан шинэчилсэн дансны үнийг “2.8.2.Ижил төстэй үзмэр, эд өлгийн зүйлээсээ хожуу цаг үед бүтээгдсэн бол 40 хүртэлх хувиар бууруулж болно.” гэсний дагуу үнийн дүнгээс 40% хасаад 180,000.0₮ боллоо.

“Иж бүрэн хувцас” үзмэрийн бүртгэлийн үнэ нийт: 1,080,000.0 ₮ болж байна.

Видео хичээл үзэх линк: www.monheritage.mn/video2.aspx




Монгол Улсын сангийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 140 тоот тушаалаар "Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам" батлагдсантай холбогдуулан музейн үзмэрийн бүртгэлийн үнийг шинэчлэн тогтоож Музейн үзмэрийн ерөнхий бүртгэлийн Register програмд оруулан хадгалахад шаардлагатай програмын нэмэлт өөрчлөлтийн ажил хийгдэж дууслаа.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг Register програмд суулгахын тулд програмын сайжруулалт (Update)-ийг татна.

ПРОГРАМЫН САЙЖРУУЛАЛТ ТАТАХ (UPDATE)

Програмын сайжруулалт татах

Програм ажиллах бүрдээ интернэт холболтыг шалгаж серверт програмын сайжруулалт орсон эсэхийг шалгадаг. Хэрэв програмын шинэ сайжруулалт гарсан бол доорх цонх гарч ирэх бөгөөд энэ үед ОК товч дээр дарж програмын сайжруулалтыг татна. Програмын



сайжруулалт татах хугацаа таны интернэтийн хурдаас шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд сайжруулалт татаж дуусаад програм өөрөө нээгдэх учир програм нээгдэх хүртэл хүлээх хэрэгтэй.

Програмын хувилбар (version)-г харгах




Үдсэн цонхны баруун доод буланд програмын хувилбарын тухай мэдээлэл байна. Хэрэв хамгийн сүүлийн сайжруулалтыг амжилттай татсан бол Version 1.1.1.8 болсон байх ёстой. Програмын сайжруулалт татахтай холбоотой ямар асуудал байгаа Соёлын өвийн төв-тэй холбогж зөвлөгөө авна уу.




REGISTER ПРОГРАМААР ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛИЙН ҮНЭ ТОГТООХ

Програмын “Дурсгалууд” цэсрүү орж “Бүртгэлийн үнэ оруулах төлөв” /Зураг 1/ товч дээр дарна. Энэ үед Бүртгэлийн үнэ оруулах төлөв идэвхжиж дурсгалын жагсаалтаас дурсгал сонгож хулганы зүүн товчийг хоёр товшиход Бүртгэлийн үнэ тогтоох цонх /Зураг 2/ гарч ирнэ.



Зураг 1




Зураг 2

Тухайн үзмэрийг нийтэд нь үнэлэх эсвэл бүрдэл тус бүрээр үнэлж нэгтгэх сонголтоос аль тохирохыг сонгоно.


НЭГ. НИЙТЭД НЬ ҮНЭЛЭХ

1.1. “Нийтэд нь үнэлэх” сонголтыг сонгож товчийг дарна. /Зураг 3/



Зураг 3

1.2. Үлгэрчилсэн үнийн сонголтоос тухайн үзмэрт тохирох төрөл зүйлийг сонгоно. Энэ үед програм автоматаар тухайн төрөл зүйлийн шинэчилсэн дансны үнийг авна /Зураг 4/.



Зураг 4



1.3. Хэрэв шинэчилсэн бүртгэлийн /дансны/ үнэ тогтоохдоо журмын 2.3-д заасанчлан бүртгэлийн үнийг өсгөж, бууруулахаар бол холбогдох заалтыг сонгож, тохирох хувийг тоон утгаар оруулна /Зураг 5/.

2.5 Ховор байдал [Сонгоно уу]

2.6 Түүх, Соёл, Шинжлэх ухааны ач холбогдол Ач холбогдол ихтэй (40 хүртэл)

2.6 Сонгосон утга (%) 0

2.7 Хийсэн материал [Сонгоно уу]

2.8 Бүтээсэн он цаг [Сонгоно уу]

Зураг 5

Анхааруулга: Бууруулах хувийг хасах (-) утгаар оруулна.

Жишээ нь: 20 хувиар бууруулахаар бол -20 гэж оруулна.
Өсгөх хувийн өмнө + тавихгүй.

1.4. Хуулбар үзмэрийн хувьд “Хуулбар эсэх” сонголтыг идэвхижүүлж журмын 2.11-д заасанчлан шинэчилсэн дансны үнийн дүнгээс бууруулах хувийг оруулах юм уу Хуулбар хийсэн өртгийг оруулна /Зураг 6/.

2.11 Хуулбар эсэх Тийм

2.11 Сонгосон утга (%) 0

2.11 Хуулбар хийсэн өртөг 0

Зураг 6

1.5. Шинэ журмын дагуу тооцоолон гаргасан үнэ тухайн үзмэрийн бодит үнээс зөрүүтэй байгаа тохиолдолд доорх сонголтоос тохирохыг сонгож болно /Зураг 7/.

Үлгэрчилсэн үнээс тооцоолон гарсан үнэ тухайн үзмэрийн бодит үнээс зөрүүтэй гарч байгаа тохиолдолд [Сонгоно уу]

Болих

Сонголт арилгах

- Худалдаж авсан үнийг баримтлах
- Үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан үнийг баримтлах
- Хуучин дансны үнийг баримтлах
- Хуулбар хийсэн үнийг баримтлах

Зураг 7

1.6. Үнийг тооцоолон дэлгэцэнд харж болно /Зураг 8/.

Үнэ тооцох

Зураг 8

1.7. Шинэчилсэн дансны үнийг тооцоолж дууссан бол Хадгалаад гарах /Зураг 9/ товчийг дарна. Энэ үед Бүртгэлийн шинэчилсэн үнэ хадгалагдах болно.

Хадгалаад гарах

Зураг 9



ХОЁР. БҮРДЭЛ ТУС БҮРЭЭР ҮНЭЛЭН НЭГТГЭН ТОГТООХ

2.1. “Бүрдэл тус бүрээр үнэлэх” сонголтыг сонгоно. /Зураг 10/

Нийтэд нь үнэлэх
 Бүрдэл тус бүрээр үнэлэх

Зураг 10

2.2. Бүрдэл тус бүрийг оруулна Ингэхдээ Бүрдлийн нэрийг бичиж “Бүрдэл хэсэг нэмэх” товч дээр дарна /Зураг 11/.

Бүрдлийн нэр:

Зураг 11

2.3. Оруулсан бүрдэл бүрийн ард байх “Үнэлэх” товч дээр дарж үнэлнэ. Үүнээс цааш энэхүү гарын авлын 1.2-1.7 той адилаар явна /Зураг 12/.

Хувийн дугаар	Үзмэрийн нэр	Шинэчилсэн бүртгэлийн үнэ	
54.01.1-11	Иж бүрэн хувцас		
Гутал	0.00	<input type="button" value="Үнэлэх"/>	<input type="button" value="−"/>
Дээл	0.00	<input type="button" value="Үнэлэх"/>	<input type="button" value="−"/>
Малгай	0.00	<input type="button" value="Үнэлэх"/>	<input type="button" value="−"/>

Бүрдлийн нэр:

Зураг 12